



МОНГОЛ УЛСЫН  
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/141

Улаанбаатар хот

Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох  
талбайн солбицлыг нийтэд мэдээлэх, бүртгэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг, Засгийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 37 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 37 дугаар тогтоолоор батлагдсан сонгон шалгаруулах журмаар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл нэмж олгох талбайн солбицлыг нийтэд мэдээлэхийг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга /Б.Баатарцогт/, Геологийн бодлогын газрын дарга /Д.Ганбат/-д тус тус даалгасугай.

2. Засгийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 37 дугаар тогтоолоор батлагдсан сонгон шалгаруулах журмаар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицлыг Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн зураг зүйн бүртгэл, мэдээллийн санд бүртгэхийг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга /Б.Баатарцогт/-д зөвшөөрсүгэй.

3. Сонгон шалгаруулах журмаар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон ажлыг зохион байгуулахдаа холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг биелүүлж ил тод, хариуцлагатайгаар ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга /Б.Баатарцогт/-д даалгасугай.

4. Засгийн газрын тогтоолоор тогтоосон солбицол бүхий талбайд сонгон шалгаруулах журмаар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулах бэлтгэлийг яаралтай хангахыг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга /Б.Баатарцогт/-д даалгасугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Нандинжаргал/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /Ц.Одхүү/-д тус тус үүрэг болгосугай.

САЙД



Ц.ДАШДОРЖ